



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2018

ИТХ-ын ажлын
алба
2018.12.17





БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ





АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2018 оны ажлын
төлөвлөгөөнд 5 бүлэг 44 заалт
төлөвлөснөөс төлөвлөгөөний
хэрэгжилт 81 хувьтай байна



Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаа

Сумын ИТХ-ын хуралдаан 4 удаа хуралдаж 20 тогтоол батлан гаргав.

Сумын
ИТХ-ын хуралдаан





ИТХ-ын хуралдааны шийдвэр

№	Хуралдаан	Сар, өдөр	Хэлэлцсэн асуудал
1	Ээлжит 10 дугаар хуралдаан	IV/12	Сумын 2018 оны төсвийг өөрчлөн батлах тухай
2	Ээлжит 11 дүгээр хуралдаан	VII/16	<ul style="list-style-type: none"> -Сумын Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай -Сумын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт -Зарим газар нутгийг тусгай хамгаалалтанд авах тухай -Архигүй-Эрүүл амьдрал” хөтөлбөр батлах тухай -Гэрээ байгуулж, хамтран ажиллах тухай -Нөхөрлөлийн иргэдээс хураах төлбөрийн хувь хэмжээ тогтоох тухай -Гудамж хорооллын байршлын нэршил тогтоох тухай -Газар нутгийн үнэлгээний бүсчлэлийн хил зааг тогтоох тухай -Газрын төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай
3	Ээлжит 12 дугаар хуралдаан	X/12	Сумын 2017 оны төсвийн дансны үлдэгдэл хуваарилах тухай
4	Ээлжит 13 дугаар хуралдаан	XII/17	<ol style="list-style-type: none"> 1.Сумын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай 2.Сумын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай 3. Сумын 2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны төсөв батлах тухай 4.Сумын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний биелэлт, Газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөө 5.Сум хөгжүүлэх сангийн тайлан 6.Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл батлах тухай 7.Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн дээд хэмжээ, төсөл сонгон шалгаруулах тов зарлах тухай 8.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 9.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс 2018 онд хийсэн ажлын тайлан 10. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч чөлөөлөх, сонгох



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид

1

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
Хуралдаан -10

2

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
тогтоол -28

3

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
тэмдэглэл -10



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан





Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны журам

Алдарт эхийн одонд тодорхойлох тухай

Бэлчээрийн эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Эрүүл мэндийн салбар зөвлөлийн төлөвлөгөө

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд

Жаргалант суманд хийх ажлын төлөвлөгөө

Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Жаргалант суманд хийх ажлын төлөвлөгөө

Эргэлтийн эмийн сангийн хяналтын зөвлөл байгуулах тухай

Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай

Нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих тухай

Ахмадаа ачилъя аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд

2018 онд хийх ажлын төлөвлөгөө

Соёлч өрх, соёл орц, соёлч хот айл шалгаруулах журам

Хамтарсан багийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай

Сумын сүлд тэмдэг, тугны эх загвар батлах тухай

Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудаас



Зохион байгуулсан арга хэмжээ

Сумын хөгжилд
эмэгтэйчүүдийн
оролцоо II

Гэр бүлийн
үнэ цэнэ II

Чуулган

Сумын хөгжилд
хүүхдийн
оролцоо II

Сумын хөгжилд-
Ахмадын
оролцоо



“Сумын хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо II” эмэгтэйчүүдийн чуулган

Сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Сумын хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо -II” эмэгтэйчүүдийн чуулганыг 2018 оны 03 дугаар сарын 07 -ны өдөр сумын Соёлын төвд амжилттай зохион байгуулсан. Чуулганд 4 багийн 80 гаруй эмэгтэйчүүд оролцож сум орныхоо хөгжил дэвшилд өөрсдийн оруулах хувь нэмэр, эмэгтэйчүүдийн дунд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудаар бүтэн өдрийн турш хамтдаа чуулсан.





Сумын хөгжилд –Ахмадын оролцоо” ахмадын чуулган

Сумын ЗДТГ-тай хамтран “Сумын хөгжилд- Ахмадуудын оролцоо” чуулганыг 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр амжилттай зохион байгууллаа.





Сумын хөгжилд –Хүүхдийн оролцоо II” хүүхдийн чуулган



Сумын ЗДТГ, Байдраг ахлах сургууль, хамтран “Сумын хөгжилд –Хүүхэд бидний оролцоо II” чуулганыг амжилттай зохион байгууллаа. Чуулганд Байдраг ахлах сургуулийн анги бүрийн төлөөлөл 105 сурагч, цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 5 сурагч нийтдээ 110 хүүхэд оролцсон.



“ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭНЭ II” ЗАЛУУ ГЭР БҮЛИЙН ЧУУЛГАН



Аймгийн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран “Гэр бүлийн үнэ цэнэ-2” залуу гэр бүлийн чуулганыг 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан. Чуулганд 30 гаруй залуу гэр бүл оролцсон.





Зохион байгуулсан арга хэмжээ

Төрийн албан
хаагчдын дунд шатрын
ТЭМЦЭЭН

ИТХ-ЫН
НЭРЭМЖИТ
ТЭМЦЭЭН

Софт волейволын
ТЭМЦЭЭН

Сурагчдын дунд
шатрын ТЭМЦЭЭН



СОФТ ВОЛЕЙВОЛЫН ТЭМЦЭЭН

Иргэдийн амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулах, бүх нийтээрээ биеийн тамираар хичээллэдэг болгох зорилгоор 40-өөс дээш насны иргэдийн дунд ИТХ-ын нэрэмжит “Софт волейвол”-ын тэмцээн зохион байгуулсан. Тэмцээнд нийт 12 баг оролцсоноос Байдраг ахлах сургуулийн тамирчид тэргүүн байр, Нам толгой 1 дүгээр багийн тамирчид дэд байр, Байдраг ахлах сургуулийн тамирчид гутгаар байр тус тус эзэлсэн. Тэмцээнд ач холбогдол өгч, байгууллагынхаа ажилчид болон хариуцсан гудамж, хорооллын иргэдийг хамруулсан Байдраг ахлах сургуульд Цом, Талархал хадгалуулсан.



СОФТ ВОЛЕЙВОЛЫН ТЭМЦЭЭН





Төрийн албан хаагчдын дунд шатрын тэмцээн зохион байгуулав

Төрийн албан хаагчдын оюуны хөгжлийг дэмжих, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, орон нутагт шатрын спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, шатар сонирхогчдын тоог нэмэгдүүлэхэд зорилгоор Төрийн албан хаагчдын дунд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит шатрын тэмцээнийг 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Тэмцээнд байгууллага бүрээс 3 эмэгтэй, 3 эрэгтэй оролцсон 6 гишүүнтэй холимог баг оролцсон бөгөөд багийн гишүүд болон багийн дүнгээр шалгаруулж байр эзлүүлсэн. Тэмцээний эрэгтэй төрөлд тэргүүн байр ЗДТГ-ын байгаль хамгаалагч Д.Тайванжаргал, дэд байр ЗДТГ-ын нягтлан бодогч Д.Баттөр, гутгаар байр Байдраг ахлах сургуулийн багш Б.Жанчивдорж нар шалгарсан бол эмэгтэй төрөлд тэргүүн байр Байдраг ахлах сургуулийн багш Б.Ууганцэцэг, дэд байр Байдраг ахлах сургуулийн багш Д.Алтантуул, гутгаар байр Сум дундын эмнэлгийн эмийн санч Т.Цэцэгсүрэн нар шалгарсан. Байгууллагын дүнгээр Байдраг ахлах сургууль шалгарч шилжин явах цом, өргөмжлөл, 100000 төгрөгөөр шагнуулсан.



Төрийн албан хаагчдын дунд шатрын тэмцээн зохион байгуулав





Сурагчдын дунд шатрын тэмцээн зохион байгуулав

Сурагчдын дунд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит шатрын тэмцээнийг 2018 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр зохион байгуулав. Тэмцээн нь сурагчдын сэтгэхүй, оюуны хөгжлийг дэмжих, Өсвөрийн шатарчдын ур чадварыг, Шатрын спортыг хөгжүүлэх, сурталчлах нэмэгдүүлэх зорилготой юм.

Тэмцээн 1-5 дугаар анги, 6-9 дүгээр анги, 10-12 дугаар анги эрэгтэй, эмэгтэй төрлөөр явагдсан.



Сурагчдын дунд шатрын тэмцээн зохион байгуулав





Зохион байгуулсан арга хэмжээ

Нэг иргэн-Нэг ном
НОМЫН ХАНДИВЫН
АЯН

Зохион
байгуулсан
арга хэмжээ

"Ахмадаа сонсоё"
уулзалт ярилцлага



“НЭГ ИРГЭН-НЭГ НОМ” НОМЫН ХАНДИВЫН АЯН

Байдраг ахлах сургуулийн дотуур байрны номын сан хөмрөгийг баяжуулах, сурагчдыг номтой нөхөрлүүлэх, ном унших идэвхийг өрнүүлэх зорилгоор “Нэг иргэн-Нэг ном” номын хандивын аяныг Сумын ИТХ, Соёлын төв хамтран зохион байгуулсан. “Нэг иргэн-Нэг ном” номын хандивын аяны удирдамжийг 2018 оны 09 сарын 17-ны өдөр боловсруулан төрийн болон төрийн бус байгуулагуудад тарааж, 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл хүлээн авсан. Аяны хүрээнд Засаг даргын Тамгын газар-13, Иргэдийн төлөөлөгчдийн хурал-3, Байдраг ахлах сургууль -70, Сум дундын эмнэлэг-24, Цэцэрлэг-32, Соёлын төв-6, иргэд-5 тус тус номыг хандивлалаа. Нийт 153 ширхэг номыг Байдраг ахлах сургуулийн дотуур байрны номын санд хүлээлгэн өгсөн. “Нэг иргэн-Нэг ном” номын хандивын аянд идэвхтэй оролцож удирдамжийн дагуу номоо хандавчиган Сум дундын эмнэлэг, иргэн М.Төгсгэрэл нарыг шагнаж урамшууллаа.



“НЭГ ИРГЭН-НЭГ НОМ” НОМЫН ХАНДИВЫН АЯН





‘АХМАДАА СОНСОЁ’ УУЛЗАЛТ ЯРИЛЦЛАГА

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас "Ахмадаа сонсоё" уулзалт ярилцлагыг 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтанд ахмадын төлөөлөл 10 гаруй ахмадууд оролцлоо. Энэхүү уулзалтын зорилго нь тэдний санал хүсэлтийг сонсох, цаашид хамран ажиллах, мэдээ мэдээлэл хүргэх зорилготой юм. Ахмадуудаас гаргасан саналаас дурьдвал: Суманд ирсэн тусламж дэмжлэгийн талаар болон бусад мэдээ, мэдээлэл хүргэх, ахмад настны зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургуулийн сурагчид, залуучууд гэх мэт зорилтот бүлгээр сургалт зохион байгуулах, хог цэвэрлэгээнд анхаарах гэх мэт саналууд гарав. Ахмадууд маань өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан сургалт, зөвлөх үйлчилгээ гэх мэт чиглэлээр сум орон нутагтай хамтран ажиллах боломжтойгэв.





ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Орон нутгийн
хөгжлийн
сангийн
хөрөнгөөр
хийгдэж буй
ажлууд

Сум хөгжүүлэх
сан

Шилэн
дансны тухай
хуулийн
хэрэгжилт

Хяналт
шалгалт

Өмч хөрөнгийн
хадгалалт
хамгаалалт

Байгаль
орчны хууль
ТОГТООМЖ

Шашны үйл
ажиллагаа



ХЯНАЛТ ШАЛГАЛТ

2

Орон нутгийн хөгжлийн
сангийн гүйцэтгэлд
хяналт тавьсан

Багуудын худаг засвар

Цэвэр усны шугамд холбох
ажлын гүйцэтгэлд





ХЯНАЛТ ШАЛГАЛТ

3

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2018 оны 03 дугаар захирамжаар томилогдсон Ажлын хэсэг 2018 оны 09 дүгээр сарын 17-20-ны хооронд төсөвт байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд удирдамжийн дагуу хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтад Засаг даргын Тамгын газар, Байдраг ахлах сургууль, Сум дундын эмнэлэг, Цэцэрлэг, Соёлын төв хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчлийн арилгах талаар зөвлөмж хүргүүлсэн.

Ажлын хэсэг нь сумын төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй цаашид ашиглах боломжгүй, эвдэрч гэмтсэн 119 нэрийн 61428119,87 төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг нүд үзэн, нэг бүрчлэн шалгаж, актлах шийдвэр гаргуулан, устгах үйл ажиллагааг зохион байгуулсан.





ХЯНАЛТ ШАЛГАЛТ

4

Иргэдээс ирсэн гомдол, мэдээллийн дагуу ИТХ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг Хөндлөн булаг 3 дугаар багийн нутаг Мандалын бөөрөгт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй Жамп ХХК, Агь Хаарьвист ХХК болон бичил уурхай эрхлэгчийн үйл ажиллагаанд 3 удаа хяналт шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.





ХЯНАЛТ ШАЛГАЛТ

5

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн зээлийн эргэн төлөлтөнд 2018 оны 09 сарын 08-09ны хооронд хяналт шалгалт хийсэн. Шалгалтын дүнг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.



ХЯНАЛТ ШАЛГАЛТ

6

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд Б.Өнөрбаяр, Д.Уранчимэг, Ц.Туул, Ш.Жадамбаа нар 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр суманд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтад тус суманд үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэван” хийд, “Авралын үг” сүмүүд хамрагдлаа. Эрдэнэвангийн хийд нь үйл ажиллагаа явуулахгүй байгаа учраас шороо тоосондоо дарагдсан, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт муу байна. Иймд Эрдэнэвангийн хийдийг байнгын үйл ажиллагаатай болгож, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, тооллогоор дутагдсан эд зүйлийг 2018 оны 10 дугаар сард багтаан хийдэд төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Засаг даргын Тамгын газар болон Соёлын төвд үүрэг болгосон.





БУСАД АЖЛЫН ТАЛААР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт сургалт зохион байгуулж, цаг үеийн болон цаашид хийх ажлын талаар арга зүйн зөвлөмж өглөө. Мөн багийн ИНХ-ын дарга нарын ажил дүгнэх үзүүлэлтийн төслийг танилцуулж, санал хүсэлтийг авлаа.





БУСАД АЖЛЫН ТАЛААР

“Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсан өдөрт зориулсан Улсын Их Хурлын дарга М.Энхболдын ивээл дор Шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр зохион байгуулсан. Тус тэмцээний эрэгтэй шатрын төрөлд Д.Гантөмөр түрүүлж, хоёрдугаар байрт С.Ариунсан, гуравдугаар байрт Д.Дашцэрэн нар шалгарсан. Эмэгтэй шатрын төрөлд М.Баасанбаяр түрүүлж, хоёрдугаар байрт А.Түмэнжаргал, 3 дугаар байрт Г.Ууганцэцэг нар шалгарсан. Шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээнд эхний байр эзэлсэн эрэгтэй 3, эмэгтэй 1 тамирчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийн бичиг гардуулсан. Эрэгтэй эмэгтэй эхний гурван байрыг шалгаруулж, мөнгөн шагналаар шагнасан.

ШАТРЫН ТЭМЦЭЭН



БУСАД АЖЛЫН ТАЛААР

ХАСХОМ

2018 онд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, сум, багийн Засаг дарга, Засаг даргын орлогч нийт 24 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргуулан авч, тайланг мэдээг гаргаж аймагт хүргүүлсэн. Хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт оруулсан нэг албан тушаалтны мэдүүлгийг хүлээн авч, баталгаажуулсан.



Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөл

Хэлмэгдэгсдийн ач, зээ нарт хүндэтгэл үзүүлэв.



Жил бүрийн есдүгээр сарын 10-ны өдрийг Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэсний дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба тус өдрийг 9 дүгээр сарын 10-ний өдөр зохион байгууллаа. Энэхүү тэмдэглэлт өдрийн хүрээнд хэлмэгдэгсдийн ач, зээ нарын төлөөллийг хүлээн авч уулзан тэдний санал бодлыг сонсож, гарын бэлэг гардуулан, хэлмэгдэгсдийн хойчийн буянд зориулж ном хуруулах арга хэмжээг зохион байгуулав.



Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөл

ХУУЛЬ СУРТАЛЧЛАВ.

**УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ,
ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИАС**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зарим өөрчлөлтүүд орсон.

Тухайлбал: Тус хуулийн 13 дугаар зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд олгох нөхөх олговрын хэмжээ

13.2. Энэ хуулийн 23.1-д заасны дагуу орон сууц аваагүй улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид дараах нөхөх олговрыг дор дурдсанаар олгоно:

13.2.1. Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 80 сая төгрөг

13.2.2. Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгч, хэлмэгдэгч нас барсан бол түүний эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 40 сая төгрөг.

6.3 Цагаатгуулах тухай гомдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн

Page: 2 of 3 Words: 478 Mongolian (Cyrillic) 91%



ГХУСАЗ салбар зөвлөл

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН СУДАЛГАА

д/д	Гэмт хэргийн төрөл	2017	2018	Өсөлт, бууралт
1	Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг	4	5	+1
2	Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх гэмт хэрэг	1	0	-1
3	Хүнийг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг	2	2	-
4	Хүнийг санаатай алах	1	0	-1
5	Бусдын бие мах бодид хөнгөн гэмтэл санаатай учруулах	1	2	+1
6	Галт зэвсэг байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар орж авах	1	0	-1
7	Хууль бусаар ашигт малтмал хайх олборлох	0	5	+5
Нийт		10	14	



ГХУСАЗ салбар зөвлөл

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН СУДАЛГАА

Дээрх тоон мэдээнээс харахад 2017 онд нийт 10 гэмт хэрэг, 2018 онд нийт 14 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд онтой харьцуулахад гэмт хэргийн гаралт 4 буюу 40 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь тодорхой төрлийн гэмт хэргүүд буюу мал хулгайлах болон хууль бусаар ашигт малтмал хайх олборлох гэмт хэргүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Цаашид энэ төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх ажил арга зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.



ГХУСАЗ салбар зөвлөл

ГХУСАЗ салбар зөвлөлийн гишүүд 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдөр хуралдаж, салбар зөвлөлийн 2018 оны ажлын төлөвлөгөөг баталсан





ГХУСАЗ салбар зөвлөл

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөө 4 бүлэг 24 заалттай бөгөөд хэрэгжилт 80 хувьтай байна.



ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан байгууллага, багуудын дунд "Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон" 21 хоногийн аян зарласан. Энэхүү аяны зорилго нь гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх, аливаа хүчирхийлэл, хулгай, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж, хамтын ажиллагааг сайжруулахад оршино. Аяныг албан байгууллага, багууд хуваарийн дагуу жилийн турш зохион байгуулах бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газар зохион байгуулах ба шилжин явах тугийг хүлээлгэн өгч, эхлүүлсэн.



ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Архигүй-Аюулгүй Жаргалантчууд” сарын аян хүрээнд 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр архины хамаарал бүхий иргэд болон архинаас гарсан иргэдийн дунд “Аюулгүй амьдралд-Иргэдийн оролцоо” нээлттэй хэлэлцүүлгийг сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт дөрвөн багийн төлөөллүүд, гудамж, хорооллын идэвхтнүүд, албан хаагчид 30 гаруй иргэд оролцсон. Хэлэлцүүлэгт иргэний үүргээ ухамсарлан оролцож, өөрийгөө ялан дийлэхийн ухааныг бусдад сурталчлан зөв үлгэр дууриалал үзүүлсэн иргэдийг “Сайн үйлстэн” өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.





ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Сумын ГХУСАЗС зөвлөлөөс санаачлан “АВЛИГАГҮЙ-ШУДРАГА АЖИЛЛАЖ, АМЬДАРЦГААЯ” дэвжээ тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр төрийн байгууллагуудын дунд зохион байгууллаа. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг сурталчлах, авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд сурталаас ангид төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийг урамшуулах зорилгоор уг тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд нийт 5 баг оролцсоноос тэргүүн байрт Сум дундын эмнэлгийн Д.Ичинхорлоо ахлагчтай “Энхийн манаа” баг дэд байрт Засаг даргын Тамгын газрын Д.Азжаргал ахлагчтай “Соёмбо” баг, гутгаар байрт Цэцэрлэгийн Д.Түмэнжаргал ахлагчтай “Нар” баг шалгарч, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшууллаа.



ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

“АВЛИГАГҮЙ-ШУДРАГА АЖИЛЛАЖ, АМЬДАРЦГААЯ” ДЭВЖЭЭ





ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

“Гэр бүл хүүхдийн болон аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд-Иргэн миний оролцоо” дэвжээ тэмцээнийг 2018 оны 10 дугаар сарын 29-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 5 багийн 75 тамирчид оюун бодол, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байранд М.Болорэрдэнэ ахлагчтай Байдраг ахлах сургуулийн “Хүүхэд эрдэнэ” баг, дэд байранд С.Жаргалсайхан ахлагчтай ЗДТГазрын Соёмбо баг, гутгаар байранд Г.Алтантуяа ахлагчтай Сум дундын эмнэлэгийн “Хүүхдийн элч” багууд тус тус шалгарч шагнагдлаа. Энэ үеэр Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, ХАБЭАхуйн тухай хуулиудаар иргэдэд дүрийн тоглолт, асуулт, хариулт, хуулиудтай холбоотой кейс дээр ажиллуулсан нь үр дүнгээ өглөө



ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал





ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Ногоон гэрэл-Цагаан шугам

-Байдраг ахлах сургуулийн 3-5 дугаар ангиудын дунд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээнийг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдөр удирдамжийн дагуу зохион байгуулсан.



ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Ногоон гэрэл-Цагаан шугам





ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Сургалт

Байдраг ахлах сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдад Гэмт хэрэг зөрчил, Архи Тамхины хор хөнөөл, Цахим орчны зохистой хэрэглээ ба хор хөнөөлөөс сэргийлэх нь сэдвийн хүрээнд ИТХ-ын дарга Ж.Уранчимэг, Нарийн бичгийн дарга Д.Уранчимэг нар 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр сургалт зохион байгууллаа.





Улаан загалмайн хорооны талаар

ТАТВАР

-2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар Монголын Улаан Загалмайн хорооны татварт 3259,0 төвлөрүүлж, гэрээний биелэлт 302 хувьтай байна. Мөн 80 иргэд, малчдыг шинээр элсүүлж, бүртгэлжүүлсэн.

Нам толгой 1 дүгээр багийн малчин Энэбишийн Мөнхбат, Өлзийт өндөр 2 дугаар багийн малчин Балданхорлоогийн Жүгдэр, Цэдэндамбаагийн Бямбаа нар “Манлай малчин” гишүүнээр элсэн тус бүр 500000 төгрөг төвлөрүүлж, бусдыгаа манлайллаа. Мөн Хөндлөн булаг 3 дугаар багийн иргэн Тогооборын Эрхэмбаяр мөнгөн гишүүнээр элсэж 100000 төгрөгийн татвар төлсөн.



Улаан загалмайн хорооны талаар

ОУУЗУХСН холбооны гамшгийн яаралтай тусламжийн сангаас санхүүжүүлж Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн хэрэгжүүлж буй өвөлжилт хүндэрсэн аймгуудын сумдын малчдад хүнс болон малын тэжээлийн багцны тусламжид 100 өрх хамруулсан. 1 өрхөд 130000 төгрөгний хүнс, тэжээл нийт 13,0 сая төгрөгийн тусламж олгосон.





Улаан загалмайн хорооны талаар

Сумын малчид, төлчдийн зөвлөгөөний үеэр сумын Улаан Загалмайн хорооны үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг болон зорилтот бүлгийн 30 өрхөд 5 кг гурил, 1 сүү, 1 хувин, 1 боодол өвс тус тус өгсөн.



2019 оны зорилго, зорилт

- ИТХ-ын Төлөөлөгчдийг чадавхжуулах
- ИТХ-ын хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- ИТХ-ын ил тод байдлыг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- Сумын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, бодлого боловсруулах



Баярлалаа

